



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/52/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 9999-3365

Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч: Г.Заяа
Утас: 9203-8288

Цахим хаяг: zayaq@audit.gov.mn

Аудитор Г.Чулуунбаатар

Утас: 9908-4581

Цахим хаяг: chuluunbaatar@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. Төрийн аудитын санал, дүгнэлт



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2022-02-24 № 1302/198
танай -ны № -т

ЗАВХАН АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
Ц.УЛАМ-ОРГИХ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

01302/132

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/мян.төг/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,077.53	5,490.43
33	АВЛАГА	2,137.53	2,137.53
335	Бусад авлага	2,137.53	2,137.53
3351	Байгууллагаас авах авлага	2,137.53	2,137.53
35	БАРАА МАТЕРИАЛ	1,940.00	3,352.90
354	Хангамжийн материал	1,940.00	3,352.90
35410	Бичиг хэргийн материал	440.00	440.00
35420	Аж ахуйн материал	00.00	2,362.90
35430	Сэлбэг хэрэгсэл	1,500.00	550.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	69,509.00	97,173.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	69,509.00	97,173.74
392	Биет хөрөнгө	69,509.00	97,173.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	65,000.00	65,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-12,593.75	-14,218.75
39203	Авто-тээврийн хэрэгсэл	133,400.00	133,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-119,750.00	-123,650.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	18,244.06	42,825.69
39206	Хуримтлагдсан элэгдэл	-17,631.13	-11,101.80
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,651.68	22,259.53
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,811.86	-17,340.93
39301	Програм хангамж	680.00	680.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-680.00	-680.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	73,586.52	102,664.16
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	73,586.52	102,664.16
51	Засгийн газрын хувь оролцоо	73,586.52	102,664.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		98,985.45	98,985.45
51101	Өмч: - төрийн	98,985.45	98,985.45
512	Хуримтлагдсан үр дүн	-33,818.16	-4,691.80
51210	Өмнөх үеийн үр дүн	-33,818.16	-33,769.44
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	29,077.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,419.23	8,370.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	73,586.52	102,664.16

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/мян.төг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,404,760.19	747,933.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,404,760.19	747,933.60
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	657,433.40	544,193.60
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	657,433.40	544,193.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	747,326.79	203,740.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	747,326.79	160,000.00

Завхан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	43,740.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,386,326.86	718,855.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,386,326.86	718,855.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,363,746.86	700,368.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	120,580.78	154,878.31
210101	Үндсэн цалин	120,580.78	104,986.18
210102	Нэмэгдэл	00.00	39,405.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	10,487.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,985.56	21,128.18
210201	Тэтгэврийн даатгал	10,201.99	14,838.67
210202	Тэтгэмжийн даатгал	1,186.86	1,638.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	983.60	1,240.24
210204	Ажилгүйдлийн даатгал	237.56	310.06
210205	Эрүүл мэндийн даатгал	2,375.56	3,100.71
2104	Хангамж, бараа материалын зардал	43,624.87	42,459.39
210401	Бичиг хэрэг	3,626.40	5,061.85
210402	Тээвэр, шатахуун	34,854.03	27,004.28
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,420.84	3,598.26
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,723.60	6,795.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,346.70	41,364.00
210604	Урсгал засвар	21,346.70	41,364.00
2107	Томилолт, зочны зардал	1,866.00	6,453.50
210702	Дотоод албан томилолт	1,866.00	6,453.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	883,046.00	335,876.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	881,402.78	334,043.49
210803	Даатгалын үйлчилгээ	1,287.00	1,287.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	197.61	396.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	158.61	150.14
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	278,296.95	98,208.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,000.00	65,715.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	225,000.00	25,043.20
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,296.95	7,449.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,580.00	18,487.28
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	13,219.09
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	13,219.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,580.00	5,268.20
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	5,268.20
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,288.90	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,291.10	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	18,433.33	29,077.64
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	18,433.33	29,077.64

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/мян.төг/ Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,985.45	8,485.15	10,460.21	117,930.81
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	98,985.45	8,485.15	10,460.21	117,930.81
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	5,073.68	5,073.68
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,985.45	8,419.23	-33,818.16	73,586.52
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,985.45	8,419.23	-33,818.16	73,586.52
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	48.72	48.72
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	98,985.45	8,419.23	-33,769.44	73,635.24
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-48.72	00.00	-48.72
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	29,077.64	29,077.64
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,985.45	8,370.51	-4,691.80	102,664.16

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/мян.төг/ Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,404,760.19	747,933.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,404,760.19	747,933.60
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	657,433.40	544,193.60
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	657,433.40	544,193.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	747,326.79	203,740.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	747,326.79	160,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	43,740.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,381,509.75	712,819.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,381,509.75	712,819.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,358,929.75	694,331.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	119,549.79	154,878.31
210101	Үндсэн цалин	100,448.30	104,986.18
210102	Нэмэгдэл	18,106.89	39,405.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	994.60	10,487.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,585.14	21,128.18
210201	Тэтгэврийн даатгал	11,647.96	14,838.67
210202	Тэтгэмжийн даатгал	1,602.29	1,638.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	974.04	1,240.24
210204	Ажилгүйдлийн даатгал	319.77	310.06
210205	Эрүүл мэндийн даатгал	2,041.08	3,100.71
2104	Хангамж, бараа материалын зардал	45,411.54	42,405.21
210401	Бичиг хэрэг	4,066.40	4,992.85
210402	Тээвэр, шатахуун	34,854.00	24,864.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,420.84	3,598.26
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,070.30	8,949.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000.00	40,414.00
210604	Урсгал засвар	20,000.00	40,414.00

Завхан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	1,866.00	6,453.50
210702	Дотоод албан томилолт	1,866.00	6,453.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	883,517.29	343,135.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	881,874.07	341,302.57
210803	Даатгалын үйлчилгээ	1,287.00	1,287.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	197.61	396.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	158.61	150.14
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	272,000.00	85,916.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,000.00	65,923.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	225,000.00	19,993.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,580.00	18,487.28
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	13,219.09
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	13,219.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,580.00	5,268.20
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,291.10	5,268.20
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,288.90	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	23,250.44	35,114.60
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	35,114.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	35,114.60
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	35,114.60
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	35,114.60
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-35,114.60
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	23,250.44	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	23,250.44	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	958,799.70	935,745.70	544,193.60	544,193.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	958,799.70	935,745.70	544,193.60	544,193.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	936,219.70	906,554.59	538,902.50	536,636.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	165,708.52	165,112.56	156,845.90	154,878.31
210101	Үндсэн цалин	114,848.70	123,115.36	114,848.70	104,986.18
210102	Нэмэгдэл	48,150.82	39,288.20	39,288.20	39,405.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,709.00	2,709.00	2,709.00	10,487.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,364.30	20,452.45	21,174.30	21,128.18
210201	Тэтгэврийн даатгал	14,330.40	14,003.09	14,900.40	14,838.67
210202	Тэтгэмжийн даатгал	1,508.50	1,602.29	1,568.50	1,638.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,206.80	1,329.54	1,254.80	1,240.24
210204	Ажилгүйдлийн даатгал	301.70	319.77	313.70	310.06

Завхан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	3,016.90	3,197.76	3,136.90	3,100.71
2104	Хангамж, бараа материалын зардал	58,164.20	58,164.20	46,064.20	45,949.81
210401	Бичиг хэрэг	6,100.00	6,100.00	5,000.00	4,992.85
210402	Тээвэр, шатахуун	43,464.20	43,464.20	23,464.20	23,464.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,600.00	3,600.00	3,600.00	3,598.26
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000.00	5,000.00	14,000.00	13,894.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,000.00	23,000.00	49,214.00	49,214.00
210604	Урсгал засвар	23,000.00	23,000.00	49,214.00	49,214.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	00.00	6,465.00	6,453.50
210702	Дотоод албан томилолт	5,000.00	4,000.00	6,465.00	6,453.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	184,200.68	176,825.38	179,139.10	179,035.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	182,319.68	174,944.38	177,258.10	177,202.57
210803	Даатгалын үйлчилгээ	1,287.00	1,287.00	1,287.00	1,287.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	396.00	396.00	396.00	396.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198.00	198.00	198.00	150.14
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	479,782.00	459,000.00	80000.00	79976.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	249,782.00	229,000.00	60,000.00	59,983.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	230,000.00	230,000.00	20,000.00	19,993.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,580.00	2,919.11	5291.10	7557.28
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	6,611.11	00.00	2,289.09
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	6,611.11	00.00	2,289.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	22,580.00	5,291.10	5,268.20
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	22,580.00	5,291.10	5,291.10	5,268.20
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	17,288.90	00.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	935,745.70	935,745.70	544,193.60	544,193.60
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	935,745.70	935,745.70	544,193.60	544,193.60
131001	Улсын төсвөөс санхүүжих	935,745.70	935,745.70	544,193.60	544,193.60
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	00.01	00.01	00.01	00.01
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	00.00	00.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.01	00.01	00.01	00.01

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/мян.төг/ Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	203,740.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	203,740.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	192,810.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,570.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,570.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	169,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	169,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8840.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,840.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,930.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	10,930.00

213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	10,930.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	203740.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	203,740.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,740.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Завхан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн, аудитор Г.Чулуунбаатар нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 19 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Завхан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагаа нь “Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж, мэргэшсэн албан хаагчдаар төрийн албыг бэхжүүлэн, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэж, аймгийн хөгжлийн төлөө ажиллах”-д оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж тус байгууллагад байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардал 579,308.2 мянган төгрөгийн 1.5 хувь буюу 8,689.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 6,517.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	2,137.53	2,137.53	0.00
Бараа материал	1,940.00	3,352.90	1,412.90
Үндсэн хөрөнгө	69,509.00	97,173.74	27,664.74
Нийт хөрөнгө	73,586.52	102,664.16	29,077.64
Өр төлбөр	0.0	0.0	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	73,586.52	102,664.16	29,077.64
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	73,586.52	102,664.16	29,077.64

Авлагын дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй, он дамжсан авлагуудыг барагдуулаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,352.9 мянган төгрөг болж өссөн нь аж ахуйн материалын худалдан авалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 97,173.74 мянган төгрөг болж өссөн нь машин тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 102,664.16 мянган төгрөг болж өссөн нь хуримтлагдсан үр дүн 29,077.64 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дээд шатны төсөв захирагч тус байгууллагын 2021 оны төсвийн зарлагыг 544,193.6 мянган төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 544,193.6 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 544,193.6 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 203,740.0 мянган төгрөгийн, нийт 747,933.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, 13,219.08 мянган төгрөгийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагааны болон бусад зардалд 734,714.52 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 203,740.0 мянган төгрөгийн орлого хүлээн авч, 10,930.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, 192,810.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын үйл ажиллагаанд онцолж үзэх асуудал байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын үйл ажиллагааны зардал болох тээвэр шатахуун, бараа материалыг нийлүүлэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байдлыг санхүүгийн аудитаар шалгахад материаллаг алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс, 147 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроон оруулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд НББ-ийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн тайлагнаж Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар дүгнэлт гараагүй, тус байгууллагад "Итгэл" үзүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх материаллаг эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар нийт 6,502.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,000.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,502.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 0.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр тус тус шийдвэрлэсэн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар залруулсан алдаа зөрчил илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Шинэ жилийн баярыг тохиолдуулан байгууллагын ажилчдын хүүхдүүдэд бэлэг олгосон 1,000.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон, /10*100,000/ төлбөрийг аймгийн төрийн сангийн Бусад нэр заагдаагүй орлогын 100090000955 тоот дансанд төвлөрүүлж, актын биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт албан тоотоор ирүүлэх;

4.3 Албан шаардлага

Тус байгууллагын 2021 оны төсвийг ИТХ-ын дарга захиран зарцуулсан, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны төсвийг Хурлын нарийн бичгийн дарга захиран зарцуулж, алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 03 сарын 31-ний өдрийн дотор Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт албан тоотоор ирүүлэх;

4.4 Зөвлөмж

Харилцагч байгууллагын төлбөрийн баримтгүй /и-баримт/ 3,365.0 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийсэн, 2022 онд харилцагч байгууллагын төлбөрийн баримтаар /и-баримт/ баталгаажсан ажил гүйлгээг хийх;

Холбогдох эзэн нь тодорхойгүй 2012, 2015 онд үүссэн насжилт өндөртэй 2,137.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулах;

Зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт албан тоотоор ирүүлэх;

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн ИТХ	4	6,502.5	-	-	1	1,000.0	1	0.0	2	5,502.5

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Г.ЧУЛУУНБААТАР

ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ЗАЯА

2022.02.25